



ЦУСНЫ САЛБАРТӨВИЙН  
ЭРХЛЭГЧ ЭМЧ НАРТ

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ  
ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3 дугаар хороо,  
Энхтайваны өргөн чөлөө, Утас/Факс: (976) 7011 2857,  
E-mail: nctmmgl@gmail.com

2020.12.02 № 382  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цартахал манай улс оронд голомтлон гарч улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин хорио цээрийн дэглэм мөрдөн ажиллаж байна.

Энэ үед цус, цусан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

**ШИНЭ КОРОНАВИРУСТ (COVID-19) ХАЛДВАР ГОЛОМТЛОН ТАРХСАН ҮЕД  
ЦУСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ЦУС, ЦУСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ  
ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ТӨЛӨВШҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ**

1. Цусны донор сонгох эрүүл мэндийн үзлэгийг хянуур, нямбай хийж, танадалтын асуумжийг сайн авч барирмтжуулах;

2. Цусны донорт дараах шалгуур илэрсэн бол 28-аас доошгүй хоногийн дотор цусаа өгөхийг түр хойшлуулах:

- Халууралттай, эсхүл амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн;
- Халууралттай, эсхүл амьсгалын замын өвчний шинж тэмдэг илэрсэн хүнтэй хамт байсан, байгаа;
- Шинэ коронавируст (COVID-19) халдвартай нь батлагдсан хүнтэй хамт байсан, ойр дотно харилцаатай байсан зэрэг өгүүлэмжтэй;
- Шинэ коронавируст (COVID-19) халдварын тохиолдол гарсан улс орнуудад зорчсон өгүүлэмжтэй бол;
- Зэрлэг амьтантай шууд харьцдаг бол.

3. Хэрэв цусаа өгснөөс хойш 14 хоногийн дотор шинэ коронавируст (COVID-19) халдвартай ижил шинж тэмдэг илэрсэн, эсхүл хорио цээр, тусгаарлалтанд орсон бол энэ тухайгаа Цус сэлбэлт судлалын үндэсний төв, Цусны салбар төвд заавал хариу мэдээлэх шаардлагатай талаар танилцуулж, холбогдох утасны дугаар, цахим хаягийг өгөх;

4. Цусны донороос шинэ коронавируст (COVID-19) халдвартай ижил шинж тэмдэг илэрсэн, эсхүл хорио цээр, тусгаарлалтанд орсон талаар мэдээлсэн тохиолдолд дараах арга хэмжээ авах:

- Тухайн донорын цуснаас үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хорионд авах, устгах;
- Эрүүл мэндийн байгууллагад олгосон тохиолдолд уг бүтээгдэхүүнийг буцаан татаж авч, хорионд байлгах;
- Хэрэв бүтээгдэхүүнийг өвчтөнд сэлбэсэн тохиолдолд тухайн Эрүүл мэндийн байгууллагын удирдлага энэ талаар Эрүүл мэндийн яам, Цус сэлбэлт судлалын үндэсний төвд мэдэгдэх;

- Тухайн цусны донорт үйлчилсэн ажилтны эрүүл мэндийг хянах, шинж тэмдэг илэрвэл шуурхай тусгаарлах;

- Хорио цээр, тусгаарлалтын хугацаа дуусмагц цусны донорыг давтан үнэлж, халдвар аваагүй тохиолдолд бүтээгдэхүүнийг хорионоос чөлөөлөх.

5. Цусны алба нь гамшиг нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үед цусны донорын сургалт сурталчилгаа, элсүүлэлтийг олон талт хэлбэр (утас, мессэж, нийгмийн сүлжээ, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, сурталчилгааны самбар г.м)-ээр хийх;

6. Цус цуглуулах үйл ажиллагааг нэг дор олон хүн бөөгнөрүүлэхээс зайлсхийх, хүн хоорондын зайг баримтлах, эс, сийвэнг цаг товлосон байдлаар зохион байгуулах, шаардлагатай бол донорыг тээврийн хэрэгслээр зөөж авчран цус, эс, сийвэнг авах;

7. Орон нутагт ЦСТ эмнэлгийн байранд ажилладаг тул донорууд ирж цус өгөх боломжгүй болж байна. Иймд байгаа газар нь очиж цус, цуглуулах ажлыг зохион байгуулах ба цус цуглуулах автомашиныг тухай бүр цэвэрлэж, халдваргүйжүүлэх;

8. Цусны донор бүрийг амны хаалт /маск/, гар халдваргүйжүүлэх бодис хэрэглэх нөхцөлөөр хангах;

9. Халдварын тохиолдол гарсан үед цус цуглуулахдаа донор хоорондын зай нэг метрээс доошгүй байх, донорын сандал бүрийг тусгаарлах, донор бүрийн дараа халдваргүйжүүлэлт хийх;

10. Базуур бөмбөгийг нэг удаа хэрэглэх уутаар бүрхэж, тухай бүр халдваргүйжүүлж байх;

11. Цус цуглуулах өрөөний температурыг цельсийн 22-25 орчим хэмд байлгаж, өдөрт 2-оос доошгүй удаа, 30 минутаас багагүй хугацаагаар агааржуулалт хийх;

12. Цус цуглуулах хэсгийн сандал, хаалга, шат болон цахилгаан шатны бариул, товчлууур, ажлын талбай, шал, багаж хэрэгслийг хлор агуулсан халдваргүйжүүлэх уусмалаар ажил эхлэхийн өмнө, дууссаны дараа болон бохирдсон тохиолдол бүрт халдваргүйжүүлэх;

13. Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн Нэгдсэн эмнэлэг шаардлагатай үед Хөлдөөсөн шинэ сийвэн, К сийвэн зэрэг бүтээгдэхүүнийг ЦССҮТ-д захиалан, нөөц бүрдүүлэх;

14. Цус, цусан бүтээгдэхүүнийг хүлээн авах, тээвэрлэхдээ халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлах.